

DOCTOR MEIC

Хэрэглэгчдэд
зориулсан
сэтгүүл

2021 он
Дугаар № 12

МОНГОЛ ЭМ ИМПЭКЗ КОНЦЕРН

ШҮРШДЭГ ФТОР

*Шүдээ хамгаалах
хялбар арга*

ФТОР БОЛОН КСИЛТОЛ
АГУУЛСАН ШҮРШЛЭГ



OLVITA

Алдрай үрийн тань
АНХНЫ ВИТАМИН



ОЛВИТА витамин нь найрлагандаа 11 төрлийн аминдэм (тосонд уусдаг А, D3, Е усанд уусдаг В1, В2, В5, В6, В12, РР, С, Н) агуулсан учир хүний биед шаардлагатай витаминь хэрэгцээг нөхөж, дархлааг дэмжин халдварт өвчнөөс хамгаална.

☎ Хүргэлтийн утас: 1800-1923, 9508-1923

Ч. Бауыржан:

ЦАР ТАХЛЫН ҮЕИЙН БЭЛТГЭЛ СУРГУУЛИЛТАД БИД ӨӨРСДӨӨ САНААЧЛАН ХҮСЭЛТ ТАВЬЖ ОРОЛЦСОН



Ковид-19 цар тахал дэлхий нийтийг цочроож байна. Баяр ёслолууд цуцлагдаж, сургууль, үйлчилгээний байгууллагуудад хөл хорио тогтоолоо. Бидний өдөр тутмын амьдралын хэмнэл ердөө хэдхэн сарын дотор бүрэн өөрчлөгдөв. Гэхдээ энэ үед эрүүл мэндийн салбарынхан онцгой хариуцлагатай, зогсолтгүй ажиллах цаг ирсэн юм. Тэр дундаа эм хангамжийн байгууллагын үүрэг хэчнээн чухал гэдгийг мэдрэх онцгой үе байлаа. Цар тахлын үед эм, эмнэлгийн хэрэгслийн найдвартай түгээлт, ханган нийлүүлэх ажил нэг минутаар ч хочрох ёсгүй юм. Яг энэ сэдвээр Монголын эм хангамжийн байгууллагын анхдагч Монгол Эм Импэкс Концерн хэрхэн ажиллаж байсан талаар тус байгууллагын Логистикийн газрын захирал Ч.Бауыржантай ярилцлаа.

Сайн байна уу? Танд энэ өдрийн мэндийг хүргэе. Дэлхий нийт Ковид-19 цар тахлын аюултай нүүр туллаа. Улаанбаатар болон орон нутгийн хэд хэдэн аймагт ч онцгой нөхцөл байдал үүсч хөл хорио тогтоосон. Халдварт өвчний эрсдэлтэй, урьд өмнө нь тулгарч байгаагүй нөхцөлд Монгол Эм Импэкс Концерн Логистикийн газар хэрхэн ажиллаж байна вэ?

Сайн байна уу? Тийм ээ, та бүхэн бүгдээрээ санаж байгаа байх, 2020 он хэцүү эхэлсэн. Энэ хэцүү цаг үед бид бэлэн байдлаа хангах, бусад бэлтгэл ажлуудыг сайн хангаж ажилласан. Тухайлбал, 2020 оны 5 дугаар сарын 6-8-ны өдрүүдэд УОК, ЭМЯ, ОБЕГ хамтран зохион байгуулсан “Ковид-19 цар тахлын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээ” бэлтгэл сургуулилтад манай газраас санаачлан, өөрсдөө хүсэлт тавьж оролцсон.



Тухайн үед эм хангамжийн байгууллагуудаас ганцаараа ийм санаачилга гаргаж оролцсон нь Монгол Эм Импэкс Концерн л байсан. Уг арга хэмжээний үеэр дадлага

сургуулалтанд оролцохоос гадна, хөл хорио тогтоовол, хэрхэн яаж хөл хорио тогтоосон бусийг эм, эмнэлгийн хэрэгслээр хангах вэ, эм зүйчид, бусад ажилтнууд маань хэрхэн ажиллах талаар олон асуудлуудыг Онцгой байдлын үеийн төлөвлөгөөнд тусгах саналаа хүргүүлэн ажилласан.

2020 оны эхний хагаст гарсан нэг том хүндрэл нь хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодисын хомстол байсныг та бүхэн санаж байгаа байх. Ковид цар тахлын аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор хөл хорио тогтоож, хязгаарлалт хийгдсэнтэй холбоотойгоор дэлхий нийтэд хамгаалах, хэрэгсэл, ариутгалын бодис тасарч, хүрэлцээгүй болох зэрэг хүндрэлүүд улсын хэмжээнд гарсан бөгөөд бид бүхэн байгаа нөөцөө нэн шаардлагатай газар нь нэн яаралтай хүргэх ажлыг зохион байгуулж ажилласан. Зөвхөн хангамжийн байгууллага, улсын хэмжээнд гэлтгүй дэлхий нийтэд халдвараас хамгаалах хэрэгсэл, ариутгалын бодисын хангамжийн хомсдол, түүний нөөцийн асуудалд тулгамдсан хүндхэн цаг үе байсан. Түүнчлэн хил гааль хаасантай холбоотойгоор нэн шаардлагатай эм, тарианы нийлүүлэлт тасрах эрсдэлүүд бий болсон хэцүү цаг үе байсан хэдий ч орон нутагт эм, эмнэлгийн хэрэгслийн тасалдал үүсгэхгүй байх, цаг хугацаанд нь эм, эмнэлгийн хэрэгслээр хангах ажлыг манай хамт олон амжилттай зохион байгуулж ажиллаж чадсан.

Мөн бид Монгол Улсад ОУ-ын байгууллагуудын тусламжийн шугамаар нийлүүлэгдэж байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг тодруулбал Ковид-19-ийн оношилгоо, эмчилгээнд хэрэглэгдэж байгаа эм, тариа,

хамгаалах хувцас хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээж авах, хадгалах, хуваарилагдсан газруудад нь тээвэрлэх ажлуудыг хийж гүйцэтгэдэг. Хамгийн сүүлийн жишээ л гэхэд ЭМЯ-ны Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах төслийн хүрээнд Улсын гуравдугаар шатлалын эмнэлэг, Нийслэлийн дүүргийн эмнэлгүүд болон аймгуудад нийлүүлэгдэж байгаа амьсгалын аппаратуудын нийлүүлэх ажлыг гүйцэтгэж байна. ЭМЯ-ны түшиц газар болж, энэ хариуцлагатай ажлыг гүйцэтгэж байгаадаа бид бүхэн бахархалтай байдаг.

Хөл хорио тогтоосон, эрсдэлтэй үед манай хамт олон цаг наргүй ажиллаж, эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийг тасалдалгүй, найдвартай хангах хүчин зүтгэж байдаг манай хамт олон бол чимээгүй баатрууд юм. Манай хамт олон маш их ачаалалтай, амралтгүй, уртасгасан цагаар ажиллаж байхдаа эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ биелүүлж улс орныхоо хүнд хэцүү цагт бага ч гэсэн хувь нэмэр оруулж байгаадаа баяртай байдаг.

Ярилцлагаараа Монгол Эм Импэкс Концерны талаарх сонирхолтой мэдээллийг уншигчиддаа хүргэе. Танай өрөөнд байгаа хуучин БНМАУ-ын сүлд, Д.Сүхбаатар жанжны зураг их анхаарал татлаа, энэ байгууллагын түүхээс сонирхуулахгүй юу? Нэг зууны түүхтэй байгууллага Монголд бараг байхгүй шүү дээ.

Тэгэлгүй яахав. Нэг байгууллагын хувьд 100 жил гэдэг асар их түүх. Монгол Эм Импэкс Концерны түүх нь тэртээ 1923 онд жанжин Д.Сүхбаатарын шийдвэрээр үндэс суурь нь тавигдсан, Монголын орчин цагийн эм хангамжийн түүхийг тэр чигтээ өөртөө агуулж байгаа түүхэн замналтай байгууллага.



Монгол Эм Импэкс Концерн Улаанбаатар хот болон орон нутгийн 21 аймагт байрлах салбаруудаараа дамжуулан иргэд, эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай эм, эмийн бүтээгдэхүүнээр ханган ажилладаг. Монгол орон даяар эрүүл мэндийн бараа бүтээгдэхүүнийг найдвартай хүргэхийн тулд ямар зохион байгуулалтаар хэрхэн ажилладаг вэ?

Монгол Эм Импэкс Концерн нь эм хангамжийн чиглэлээр мэргэшсэн, үндэсний ууган байгууллага.

Манай байгууллага нь мэргэжлийн онцлог бүхий бүтэц зохион байгуулалттай. Бусад эм ханган нийлүүлэх байгууллагуудаас ялгарах нэг онцлог бол бие даасан Логистикийн газар үйл ажиллагаа явуулдаг. Хуучнаар бол 21 аймаг болон Улаанбаатар хотын эмийн сан, эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг эм, эмнэлгийн хэрэгслээр дангаараа хангах үүрэг бүхий “Эм, эмнэлгийн хэрэгслийн бааз” юм.

Бид Монгол улсын холбогдох стандартуудад нийцсэн Эм, эмнэлгийн хэрэгсэл хүлээж авах, хадгалах зориулалтын агуулах, тээврийн хэрэгслээр 21 аймагт найдвартай тээвэрлэн хүргэж ажлыг зохион байгуулж ажиллаж байна.

Эм хангамж бол хүний эрүүл мэнд, амь настай холбоотой онцгой хариуцлагатай салбар. Энэ ажил үүргийг эрсдэлгүй, хурдан шуурхай гүйцэтгэхэд ажиллах чадварлаг боловсон хүчин чухал. Монгол Эм Импэкс Концерны логистикийн газарт ажилладаг ажилтнуудын талаар танилцуулахгүй юу?

Тэгэлгүй яахав, маш өндөр хариуцлагатай ажил. Мэдээж манайд мэргэжлийн, чадварлаг, туршлагатай хамт олон ажилладаг гэдгийг би бахархалтайгаар хэлнэ. Үйл ажиллагааны хувьд импортоор ирж байгаа болон дотоодын ханган нийлүүлэгчдээс ирж байгаа эм, эмнэлгийн хэрэгсэлд чанарын хяналт тавихаас үйл ажиллагаа маань эхэлдэг. Тухайлбал, орлогын мэргэжилтэн шинээр ирсэн бараа бүтээгдэхүүнийг бүртгэж авах, дефектарууд тухайн барааг агуулахад хүлээж авах, хувиарлах, эм бэлтгэгч ачигч нар маань бэлдэх, жолооч нар гаргасан маршрутын дагуу тээвэрлэх, харилцагчдад хүлээлгэн өгөх гэх зэргээр олон хүний хүч хөдөлмөрийн үр дүнд шаардлагатай эм, эрүүл мэндийн бүтээгдэхүүн өвчтөнд очдог.

Дефектар - Эм, эмийн бүтээгдэхүүнийг харцуцан бүртгэх, хадгалах, захиалгын дагуу эм барааг бэлтгэн хувиарлах үүрэг бүхий албан тушаалтан.

Энэ хариуцлагатай ажлыг ахмад, залуу үеийн бүх төлөөл бүхий манай том хамт олон хийж гүйцэтгэж байна. Жишээ нь манайд жолоочоор ажилладаг Б.Шаравсамбуу, Ч.Эрдэнэбилэг нар маань эм, эмнэлгийн хэрэгслийг тээвэрлэх ажилд тасралтгүй 30 гаруй жил ажилласан хүмүүс байдаг. Бараг эмийн мэргэжлийн хүмүүс гэсэн үг дээ. Тээвэрлэж буй бараа бүтээгдэхүүнийхээ онцлогийг 10 хуруу шигээ мэднэ. Ахмад жолоочид маань эм, бараагаа ачаад гарахад хэчнээн хол замд явж байгаа ч гэсэн санаа амар байдаг. Энэ нь тэднийхээ сэтгэл, туршлагад нь итгэдгийнх байх. Тэд маань ч эм, тариагаа хүүхэд шигээ бөөцийлж явна шүү дээ.

Танд баярлалаа.

Агаарын Бохирдол УУШГИНЫ БҮТЦЭД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛДАГ

#УТАА #ТООСОНЦОР

Бид бохир агаараар амьсгалах үед агаарын бүх бохирдлыг уушгиндаа гүн шингээж авдаг. Энэ нь амьсгалын замд ноцтой гэмтэл учруулж өвчлөл үүсгэдэг аж. Агаар бохирдуулагч төрөл бүрийн элемент нь уушгинд мэдэгдэхүйцээр нөлөөлж цаашид уушгины өвчнөөр өвдөх шалтгаан болдог байна.

Утаа, агаарын бохирдолд Улаанбаатар хотын газар зүйн байрлал болон уур амьсгал давхар нөлөөлдөгийг дурдах хэрэгтэй. Нийслэлийн өвлийн агаар Сибирийн эх газрын антициклоны хүчтэй нөлөөнд оршдог тул газар дээрх хүйтэн агаарын давхаргыг дулаан агаарын давхарга нөмөрч, улмаар хотын агаарын бохирдол хөндийн доод хэсэгт бөөгнөрч үлддэг аж.

Хүүхдүүдэд:

1. Амьсгалын доод замын халдвар болох хатгалгаа

Насанд хүргэсэд:

2. Зүрхний ишеми өвчин
3. Цусны эргэлтийн тогтолцооны өвчин (цус харвалт)
4. Уушгины архаг бөглөрөлт өвчин
5. Цагаан мөгөөрсөн хоолой, бронхит, уушгины хорт хавдар

Улаанбаатар хотод амьдардаг хүүхдийн агаарын бохирдлоос үүдэлтэй өвчний дарамтын ихэнх хувь нь уушгины доод замын цочмог халдвар буюу хатгалгаанаас үүдэж байна.



*Сүүлийн 10 жилийн хугацаанд
10,000 хүнд ногоох амьсгалын замын
өвчлөл огцом нэмэгдэж 2.7 дахин
өссөн гэх тооцоо байна.*

Дэлхийн өвчний дарамтын судалгаанд агаарын бохирдол хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөний талаарх дэлхий нийтэд хийгдсэн судалгаа, баримт материалуудыг авч үзсэн байдаг. Энэхүү судалгаагаар агаарын бохирдол олон төрлийн өвчинд нөлөөлж байсан хэдий ч тодорхой таван өвчинд агаарын бохирдол шууд тоон хамааралтай байгаа нь ажиглагдсан байна.

Хүүхэд насандаа агаарын бохирдолд өртөх нь цаашид агаарын бохирдолтой холбоотой архаг өвчнөөр өвчлөх тохиолдлыг улам ихэсгэх магадлалтай байдаг. Тухайлбал, хүүхдийн биеийн хөгжлийн чухал үед амьсгалын замын өвчний улмаас үүссэн уушгины бүтцийн өөрчлөлт нь амьсгалын замын эрхтэнүүдэд архаг, удаан хугацааны эргэшгүй өөрчлөлт үүсэхэд хүргэдэг.

Үргэлжлэл >>>

Дэлхий дахинд жил бүр 230,000 гаруй хүүхэд гадаад орчны агаарын бохирдлоос үүдэлтэй амьсгалын доод замын хурц үрэвслээр нас бардаг бол амьсгалын доод замын хурц халдварт өвчний улмаас нас барагсдын 95% нь бага, дунд орлоготой улс орнуудад тохиолдож байна гэсэн судалгаа гарчээ. Мөн хатгалгаа өвчний улмаас нас барагсдын 81% нь 2 хүртэлх насны хүүхэд байна.

Өвчлөлийн тархалтад нөлөөлөх хүчин зүйлс

Хоол тэжээлийн дутагдал

- Дархлаа сул байх
- Цайрын дутагдал
- Д витамин дутагдал

Олон улсад хийсэн судалгаагаар хүрээлэн буй орчны бохирдол нь оршин суугчдын өвчлөлийг нэмэгдүүлэх, хүүхдийн бие махбодын өсөлт, хөгжилд сөрөг нөлөөлж, дархлалын түвшинг бууруулдаг болохыг тогтоосон байна.

Нас, хүйс, амьсгалын замын өвчлөлийн судалгаанд тулгуурлан Д амин дэмийн дутагдалтай хүүхдүүдэд өвлийн улиралд Д амин дэм хэрэглүүлэхэд амьсгалын замын хурц халдвар авах эрсдэлийг 2 дахин бууруулдаг нь ажиглагдсан байна.

Тамхидалт

Монголд 15-49 насны хүмүүсийн 64% нь тогтмол тамхи татдаг аж. Энэхүү харамсалтай тоо нь гэрийн дотоод орчны агаарын бохирдол, түүний хүүхдэд үзүүлэх хорт нөлөөний хүндрүүлэгч хүчин зүйл болж байна. 0-3 насны хүүхэдтэй эцэг эхчүүд тамхи татах нь хүүхдийн амьсгалын доод замын өвчин, тэр дундаа бронхит, багтраа зэрэг өвчнүүдийн эрсдэлийг нэмэгдүүлдэг.

herbal
medicine
ТАВИПЕК
КАПСУЛ
АВСТРИ УЛСАД ҮЙЛДВЭРЛЭВ

ЭРҮҮЛ УУШГИАР
ЧӨЛӨӨЛТЭЙ
АМЬСГАЛЦГАА

- » Агаарын бохирдлоос үүдэлтэй архаг ханиалга
- » Цагаан мөгөөрсөн хоолой болон гуурсан хоолойн хавсарсан үрэвсэл, гуурсан хоолой тэлэгдэх өвчин
- » Архаг болон цочмог гуурсан хоолойн үрэвсэл
- » Хамрын дайвар хөндийн үрэвсэл
- » Уушигны сүрьеэтэй өвчтөнүүдийн гуурсан хоолойн үрэвсэл
- » Тамхинаас шалтгаасан ханиалга
- » Найрлагандаа Лаванда цэцгийн тос агуулсан



Montavit



ХҮРГЭЛТИЙН УТАС:
1800-1923, 9508-1923



Д аминдэм хүний дархлааны системд маш чухал үүрэгтэй оролцдог. Олон төрлийн өвчний эрсдэлээс хамгаалах үйлдэлтэйг дэлхийн олон эрдэмтэн судалж нэгэнт тогтоожээ. Өмнө нь бид Д аминдэмийг зөвхөн рахит өвчнөөс сэргийлдэг гэж ойлгодог байсан бол өнөөдөр энэ аминдэм бол гайхамшиг гэдгийг эрдэмтэд онцолж байна. Тухайлбал Д аминдэм нь дархлааны системийг дараах байдлаар зохицуулдаг аж.

- Хүний төрөлхийн буюу байгалийн дархлааны хариу урвалын үйл ажиллагааг нэмэгдүүлдэг (жишээ нь макрофагууд) бөгөөд бие махбодийн өөрийн антибиотикийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлдэг байна.

- Олдмол дархлааны тогтолцооны зарим урвалыг дарангуйлж (жишээ нь Th1 эсүүд), улмаар хэт их дархлааны хариу урвал явагдах /жишээ нь харшил/ болон үрэвсэл үүсэхээс сэргийлдэг.

- Д аминдэм нь вирусийн халдвараас хамгаалахаас гадна бусад төрлийн халдваруудаас (мөөгөнцөр, шимэгч, прион) хамгаалах бие махбодийн ерөнхий хамгаалалтыг сайжруулдаг.

- Аутоиммун өвчин буюу дархлааны эмгэгийг эрсдэлийг бууруулдаг.

Сүүлийн үед дэлхий даяар хийгдэж байгаа олон тооны судалгаанууд бидний мэддэг Д аминдэмийн талаарх мэдлэгийг улам бүр өргөжүүлсээр байна. Нарны даавар буюу бидний арьсанд Д аминдэм нийлэгжих нь бие махбод кальци авах, алдах үйл явцыг тэнцвэржүүлж, ясны сийрэгжилтээс сэргийлэхээс гадна бараг бүх эс, эд, эрхтэний үйл ажиллагаанд нөлөөлдөг байна.

АНУ-ын Бостоны их сургуулийн эмч судалгаандаа Д аминдэм нь коронавирусаар өвчлөх эрсдэлийг 54% бууруулах боломжтой тухай дурджээ. Мөн тус сургуулийн Анагаах ухааны сургуулийн анагаах ухаан, физиологи, биофизикийн профессор, доктор Майкл

Холик,

"Хүмүүс ямар нэг шидэт эмийг хайж, эсвэл вакцинаа хүлээгээд ийм энгийн хирнээ гайхалтай зүйл хажууд нь байгааг анзаарахгүй байна" гэж хэлжээ.

Холик болон түүний судалгааны багийнхан Quest Diagnostics лабораторид цуглараад байсан АНУ-н 50 мужийн 190,000 гаруй иргэдийн цусны дээжийг судалж үзсэн байна. Ингэхэд КОВИД-19 өвчний халдвартай нь батлагдсан хүмүүсийн цусан дахь Д аминдэмийн хэмжээ эрүүл хүмүүстэй харьцуулахад дутагдалтай байжээ. Тодруулбал, эрүүл хүмүүсийн бие дэх Д аминдэмийн хэмжээ, халдвартай хүмүүсийнхээс 54% өндөр байсан аж.

Д аминдэм нь уушгины бусад төрлийн өвчнүүдээс сэргийлдэг бөгөөд өвчлөл хүндрэх эрсдэлийг бууруулдаг байна.

Британийн анагаах ухааны сэтгүүлд нийтлэгдсэн 11000 гаруй оролцогчдын дунд явуулсан өөр нэг судалгаагаар Д аминдэмийг нэмэлтээр хэрэглэх нь амьсгалын замын цочмог халдварын эрсдэлийг бууруулсан болохыг тогтоожээ.

Д аминдэм нь КОВИД-19 өвчинтэй холбоотой эд эрхтний үйл ажиллагааны доголдол, нас баралтын нийтлэг шалтгаан болох цитокины хэт их ялгаралтыг бууруулдаг. Тодруулбал, КОВИД-19 өвчнөөр халдварласан үед хүний бие вирусийн халдвартай тэмцэхийн тулд дархлааны системийн хариу урвал болгож цитокиныг их хэмжээгээр ялгаруулдаг бөгөөд үүнийг цитокины шуурга хэмжээн нэрлэдэг. Илүүдэл хэмжээний цитокин нь хурц үрэвслийг өдөөдөг ба цаашлаад эрхтэн системийг гэмтээж үхэлд хүргэх аюултай юм.

Д аминдэм хэрэглэх нь дээрх эрсдэлүүдээс сэргийлэх чухал ач холбогдолтой төдийгүй хүний эрүүл, урт удаан наслахад олон талаар нөлөөлдөг.



ВИТАМИН ДЗ ХЕВЕРТ

*Тэр бүлийн бүх
гишүүдэд зориулав*

Хүүхдийн тун

ВИТАМИН ДЗ ХЕВЕРТ 1000 ОУН

50 шахмал

Насанд хүрэгчдийн тун

ВИТАМИН ДЗ ХЕВЕРТ 4000 ОУН

60 шахмал

Бүх эмийн сангуудаар худалдаалж байна



Таны худалдан авсан 1 хайрцар D3 Hevert бүрээс тодорхой хувь нь Өмнөд Африкийн Буркина Фасо улсын боловсрол болон хөгжлийн төслүүдэд хандивлагдах болно.



Hevert компани нь цахилгаан эрчим хүчээ 100% сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс авдаг.

Яагааг **chicco** -г сонгох хэрэгтэй вэ?

Эх хүүхдэд зориулсан бүтээгдэхүүнээрээ алдартай Итали улсын алдарт CHICCO брэндийг яагааг хүүхдэдээ сонгох хэрэгтэй вэ? Юугаараа бусдаас онцлог вэ? Энэ талаарх сонирхолтой мэдээллийг уншигч та бүхэнд хүргэе.

Итали улсын Chicco брэндийг анх "Artsana group"-г үндэслэгч Cavaliere del Lavoro Pietro Catelli нь 1958 онд буюу ууган хүүгээ мэндэлсэн өдөр энэхүү брэндийг бий болгох санааг анх олсон байна. Өнөөдөр Chicco брэнд нь дэлхий даяар танигдсан, хүүхдийн томоохон 10 брэндийн нэг болж чадсан юм.

Pietro Catelli-н ууган хүүг Энрико гэдэг байжээ. Pietro хүүгээ өхөөрдөхдөө Кикко гэж дууддаг байсан бөгөөд энэ нь өнөөгийн алдарт Chicco брэндийн нэр болсон гэдэг.



Chicco брэндийг үндэслэгч Cavaliere del Lavoro Pietro Catelli

Chicco нь хүүхдийн өсөж торних хугацаанд гардаг бэрхшээл, бие махбодын онцлог зэргийг маш сайн ажиглаж түүнд бүрэн тохирсон бүтээгдэхүүнийг гаргадаг бөгөөд эцэг эхчүүд болон дэлхийн мэргэжилтнүүдтэй тогтмол харилцаатай байж хамтран бүтээсэн 60 жилийн туршлагатай брэнд юм.

Хүүхдийн арьс арчилгаа

Chicco брэндийн "Baby Moments" хүүхдийн арьс арчилгааны иж бүрдэл нь хүүхдийг төрснөөс нь хойш арьсыг арчилахад тохиромжтой. Парабен агуулаагүй, "Hypoallergenic" буюу харшил өгөхгүй, клиникийн туршилтаар баталгаажсан, спирт агуулаагүй, SLES, SLS агуулаагүй цэвэр ургамлын гаралтай.

Занны хөөс

Нүд хорсохгүй, Ургамлын ханд агуулсан, Хүүхдийн арьсыг зөөлөн торгомсог болгож, чийгийг хадгална. Хүүхдийн арьсыг цочроохгүй, Спирт, парабен агуулаагүй.



Шүдний оо

Алим банаан, гүзээлзгэнэ гэсэн 2 төрлийн амттай, Хүүхэд идэхэд аюулгүй, Италийн шүдний эмч нарын зөвлөж буй бүтээгдэхүүн

Хүүхдийн амны хөндийн арчилгаа

Chicco брэндийн ам арчилгааны бүтээгдэхүүнүүд нь хүүхдийн буйл болон шүдийг үр дүнтэй маш сайн хамгаалж, гэмтээхгүйгээр цэвэрлэдгээрээ давуу талтай. Бүтээгдэхүүнийг хүүхдийн онцлог тааруулж бүхий л хэрэгтэй бүтээгдэхүүнийг Chicco судалгааны төв болон мэргэжилтнүүдтэй хамтарч гаргадаг.

Хүүхэд хаана **chicco** мэнэ

Хүүхдийн
живх



Dryfit
Advanced

Чиссо брендийн живх нь хүүхдийн нас биеийн онцлогт тохирсон хэмжээ, загвартай байдаг бөгөөд хүүхдийн жингээс хамаарч өөр өөр хэмжээтэй байдаг. Та Монгол Эм Импэкс Концерны Улаанбаатар хотын болон орон нутгийн 21 аймагт байрлах салбаруудаас худалдан авах боломжтой.



Чиссо брендийн живх шинэчлэгдэж шингээх хэсэгт шингэнийг маш хурдан хугацаанд шингээж хуурай байлгах шинэ давхарга нэмэгдлээ. Энэхүү давхарга нь шингэн гадаргууд хүрсэн даруйд живхний доод хэсэгт шингээж хүүхдийн арьсанд хүрэх хэсгийг хуурай байлгана. Ингэснээр хүүхдэд тайван, тухтай мэдрэмж төрүүлнэ.



ШИНГЭН ТУСГААРЛАХ
НЭМЭЛТ ХААЛТТАЙ



БҮХЭЛ ӨДРИЙН ТУРШ
ХУУРАЙ БАЙЛГАНА



ХӨВӨН ЗӨӨЛӨН
ГАДАРГУУ



АГААРЫГ ЧӨЛӨӨТЭЙ
НЭВТРҮҮЛНЭ



Хүргэлтийн утас 1800-1923, 9508-1923



Физиологи, Анагаах Ухааны салбар дахь Нобелийн шагналыг Хеликобактерийг судалсан Австралийн хоёр эрдэмтэнд олгосон нь 10 гаруй жилийн өмнөх явдал.

Барри Маршалл уруу шилэнд байх шингэнийг нэг амьсгаагаар ууж орхив. Хэсэг хугацааны дараа түүний бөөлжис цутгаж, гэдсээр нь хатгуулан өвдөж эхэлсэн бөгөөд эмч нар түүнд ходоодны салст бүрхэвчийн үрэвсэл гэсэн онош тавьжээ. Ийнхүү Барри Маршал амь насаа золин байж хийсэн уг эрсдэлтэй туршилт Хеликобактерийг ходоодны шархлаа, салст бүрхэвчийн үрэвсэл үүсгэдэг гэдгийг батлан 20 жилийн дараа Нобелийн шагнал хүртсэн юм.

Хеликобактер мушгиа хэлбэрийн сахлаараа ходоодны салст бүрхүүлийг өрөмдөн, ходоодны доторхи ханыг хамгаалагч салслаг бүрхүүл үүсгэдэг эсийг гэмтээдэг. Ингэснээр ходоодны ханыг ходоодны хүчлээс хамгаалдаг салслаг бүрхүүл үгүй болж, ходоодны хүчил, бактерийн ялгаруулж буй шүүрлийн нөлөөгөөр ходоодны доторхи хананд үрэвсэл үүсч дараа нь шархалдаг ажээ. Энэ нь ходоодны улайлт, архаг үрэвслийг үүсгэдэг гол шалгаан болдог байна. Мөн ходоодны хатингаршил, дээд гэдэсний шарх, ходоодны шарх, цаашлаад ходоодны хавдар болж хүндрээ эрсдэлийг үүсгэдэг.

Хеликобактераар халдварласан үед хэвлийгээр цанхайх, жин буурах, цээж гашуу оргих, хоолны дуршил буурах, дотор муухай оргих зэрэг шинж

тэмдгүүд илэрдэг бөгөөд зарим тохиолдолд шинж тэмдэг илрэхгүй байх ч тохиолдол байдаг байна.

Энэхүү бактер нь байгальд тааралддаггүй, зөвхөн хүнээс хүнд дамжих бөгөөд шүд хорхойтсон, буйлны үрэвсэл болон шүдний бусад өвчний үед хүний амны хөндийд үүсч, тэндээ бөөгнөрөн, хүний шүлсэнд хадгалагдан үнсэлцэх, хэрэглэсэн аяга таваг, бохирлогдсон болон удаан хадгалагдсан хоол хүнс, бохир гараар дамжин халддаг. Томчууд бид хүүхдээ хооллохдоо халбагатай хоолыг нь өөрөө амандаа үмхэх, зажилж өгөх, соска нь унахад эх, эцэг нь амандаа үмхээд эргээд хүүхдэдээ хөхүүлэх зэрэг үйлдлүүдийг хийх нь халдварыг шууд дамжуулж байдаг. Уг бактери нь давстай эсвэл чихэрлэг орчинд илүү ихээр үржин орширч, хороо ялгаруулдаг. Тиймээс ходоодны хүчил ялгаралтыг их эсгэдэг хүнсний бүтээгдэхүүн, хоолны янз бүрийн амтлагч, соус, цэвэр сүү, түүхий ногоо, исгэлэн жимс, хэт чихэрлэг зүйл, газтай ундаа, өөхтостой мах, архидамхи зэргээс татгалзах хэрэгтэй.

Манай оронд бас нэгэн халдвар авах нөхцөл байдаг. Энэ нь хоносон хоол халааж иддэг буруу зуршил байдаг. Хоносон хоолыг халаах тусам шөл нь өтгөрч, шим тэжээлийн чанар нь буурч, бактери үржиж, ямар нэгэн халдвар авах боломжийг бүрдүүлдэг. Тиймээс өрх бүр ам бүлдээ тохирсон хэмжээтэй, амттай, эрүүл чанартай хоол хийж байх хэрэгтэй. Болсон хоолыг тэр даруй идэх ёстой ба удаан хадгалж хонуулж болохгүй.

Тамхи татахад ходоодны хүчил ихэсч өвчинг улам нэмэгдүүлэх төдийгүй ходоодны ханыг зузааруулж хавдар үүсгэх нөхцлийг бүрчүлнэ.

БРОККОЛИ /цэцэгт байцаа/ ХЕЛИКОБАКТЕРИЙН ЭСРЭГ ИДЭВХТЭЙ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛДЭГ

Брокколи идээрэй

Хеликобактерын үндсэн эмчилгээ нь антибиотик байдаг. Сүүлийн жилүүдэд эрдэмтэд эмийн эмчилгээнээс гадна брокколи буюу цэцэгт байцаа нь хеликобактерийн эсрэг идэвхтэй хариу үйлдэл үзүүлдэг болохыг олж мэджээ. Хеликобактерийн халдвар авсан хулганад Цэцэгт байцаа нь антибиотикт тэсэж үлдэж чаддаг хеликобактерийн эсрэг хүчтэй үйлчилгээтэй сульфорафан хэмээх бодисыг өөртөө агуулдаг байна.

Японы Цукубагийн Их

Сургуулийн Клиникийн

Анагаах Ухааны

Хүрээлэнгийн

Анагаах ухааны

доктор, дэд

профессор

Акинори

Янака

болон

түүний

хамтран

ажил -

лагсад

хоёр

хулгана

дээр

туршилт

хийсэн байна.

Ингэхдээ хоёр

нэг хулганад

брокколины нахиа /залуу ургамлуудад сульфорафаны агууламж өндөр байдаг тус боловсорч гүйцсэн брокколиг биш нахиаг нь өгч байсан/, нөгөө хулганад царгасын нахиа идүүлжээ.

Царгас нь найрлагын хувьд ерөнхийдөө цэцэгт байцаатай ижил боловч дээр дурдсан Хеликобактер устгах сульфорафан гэх бодис агуулдаггүй аж. Ингээд хоёр сарын дараа Хеликобактерийн хэмжээг хулгануудын өтгөнд шинжилж туршилтын өмнөх үетэй харьцуулж үзэхэд брокколи идэж байсан хулганы илт буурсан нь ажиглагдсан бол царгасын нахиа идэж байсан хулганад ямар нэг өөрчлөлт гараагүй байжээ. Гэхдээ аль ч тохиолдолд Хеликобактерийн халдварыг бүрэн устгаж чадаагүй байна.

Туршилтыг зогсоосноос хойш хоёр сарын дотор Хеликобактерийн бүх хэмжилтүүд өмнөх үзүүлэлтдээ буцаж иржээ. Доктор Акинори Янака хэлэхдээ

“Туршилтын үр дүнгээс харахад энэ эмчилгээ нь ходоодны хорт хавдраас урьдчилан сэргийлэх тустай байж болох юм. Цаашид эрсдэл өндөртэй өвчтнүүдэд удаан хугацаанд эмнэл зүйн туршилтаар туршиж, цэцэгт байцаа хэрэглэснээр ходоодны хорт хавдрын давтамж, хорт хавдар даамжрах

эрсдэлийг бууруулж

чадах

эсэхийг

тодорхойлох

болно.” гэжээ.

Мөн

АНУ-ын

эрдэмтэн

Жон

Хопкинс

брокколи

Хелико -

бактерийн эсрэг

ямар үйлдэл

үзүүлдгийг

судалжээ.

Судалгаагаар мөн л

брокколид агуулагдах

сульфорафан бодис нь

хеликобактер, тэр дундаа антибиотикт тэсвэртэй

төрлийг устгаж байгааг онцолсон байна. Хамтран

судлаач доктор Пол Талалай судалгааны тайландаа

брокколи нь антиоксидантаар баялаг тул элэгний

ферментийн идэвхжлийг дэмжиж, хеликобактерийн

халдварыг дарангуйлан, хавдар үүсэхээс сэргийлдгийг

дурджээ.

Эрдэмтэд Хеликобактерийн халдвар өндөр тархалттай,

эмчилгээний хуртээмж муу, өртөг өндөр бүс нутгуудад

брокколи эмчлэх болон урьдчилан сэргийлэхэд ашиг

тустай байж магадгүй гэж үзэж байна. Ийм ч учраас

хүнсэндээ тогтмо хэрэглэхийг ч зөвлөж байгаа юм.

Ямартай ч брокколи энгийн нэг ногоо биш ажээ.



сарын хугацаанд

шинэхэн цэцэгт байцаан буюу

брокколины нахиа /залуу ургамлуудад сульфорафаны агууламж өндөр байдаг тус боловсорч гүйцсэн брокколиг биш нахиаг нь өгч байсан/, нөгөө хулганад царгасын нахиа идүүлжээ.

Царгас нь найрлагын хувьд ерөнхийдөө цэцэгт байцаатай ижил боловч дээр дурдсан Хеликобактер устгах сульфорафан гэх бодис агуулдаггүй аж. Ингээд хоёр сарын дараа Хеликобактерийн хэмжээг хулгануудын өтгөнд шинжилж туршилтын өмнөх үетэй харьцуулж үзэхэд брокколи идэж байсан хулганы илт буурсан нь ажиглагдсан бол царгасын нахиа идэж байсан хулганад ямар нэг өөрчлөлт гараагүй байжээ. Гэхдээ аль ч тохиолдолд Хеликобактерийн халдварыг бүрэн устгаж чадаагүй байна.

“ХЕЛИКОБАКТЕРИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ ЭМНЭЛЗҮЙН УДИРДАМЖ”-Н ДАГУУХ ЭМЧИЛГЭЭ

ХЕЛИКОБАКТЕРИЙН ЗӨВ ЭМЧИЛГЭЭ




ГУДФИЛ

Эм уух заавар

Лансопризол бүрээс 30мг – 1 шахмалыг хоолноос 30 минутын өмнө уух

Амоксициллин шахмал 1000мг – 1 шахмалыг хоолны дараа уух
Кларитромицин шахмал 500мг – 1 шахмалыг “Амоксициллин шахмал 1000мг” ууснаас хойш 10 минутын дараа ууна.

Жич: Дээрх схемийн дагуу багц эмийг өглөө, орой ууна.




ГУДФИЛ ЛФ

Эм уух заавар

Лансопризол бүрээс 30мг – 1 шахмалыг хоолноос 30 минутын өмнө уух

Амоксициллин шахмал 1000мг – 1 шахмалыг хоолны дараа уух
Левофлоксацин шахмал 500мг – 1 шахмалыг “Амоксициллин шахмал 1000мг” ууснаас хойш 10 минутын дараа ууна.

Жич: Дээрх схемийн дагуу багц эмийг өглөө, орой ууна.



АМБИС 120

Ходоод, 12 хуруу гэдэсний шархлаа болон хеликобактерийн эсрэг *h.pylori*-н 1-р сонголтийн дөрвөлсөн эмчилгээнд хэрэглэнэ.

Висмутийн давс 120 мг - 2 шахмалыг хоолноос 20 минутын өмнө буюу “Лансопризол 30мг” эм ууснаас хойш 10 минутын дараа ууна.

Жич: Дээрх схемийн дагуу багц эмийг дөрвөлсөн эмчилгээний үед өглөө, орой ууна.



УТЛАГА ЭМЧИЛГЭЭ

ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ, АНХААРАХ ЗҮЙЛС

Утлага эмчилгээ нь гуурсан хоолойг өргөсгөх, гуурсан хоолойн үрэвсэл дарах, цэрийг ховхолж, шингэлэхэд чухал үүрэгтэй. Мөн арьсанд чийгшил өгөх, тэжээлийн бодисыг арьсанд шингээх зэрэг гоо сайхны ач холбогдлыг ч дурдаж болно.



Эмчилгээний утлага

Аливаа эмчилгээг үйлчлэх хүрээгээр нь хэсэг газрын болон ерөнхий гэж ангилдаг. Эмгэгтэй газарт хүрч очиж үйлчилгээ үзүүлэх гэдэг утгаараа хэсэг газрын эмчилгээ нь хамгийн үр дүнтэй юм.

Бид гадаад орчинтой гадна талаасаа арьс салстаараа, дотор талаасаа амьсгалын эрхтэн тогтолцоогоороо шууд харьцдаг. Утлага эмчилгээ нь амьсгалын зам буюу гуурсан хоолойн аль ч хэсэгт хүрч очиж эмийн үйлчилгээг үзүүлдгээрээ өндөр үр дүнтэй байдаг.

Эмчилгээний заалт

- Амьсгалын дээд зам, уушги, гуурсан хоолойн архаг өвчнүүд, мэргэжлээс хамаарах амьсгалын замын өвчин, амны хөндийн хурц ба архаг өвчин, дунд чих, хамрын хөндийн хурц архаг өвчнүүд, вирусээр үүсгэгдсэн амьсгалын замын өвчнүүд, салст бүрхүүлийн гэмтэл, төвөнх залгиурын үрэвслийн үед хэрэглэнэ.



- Гуурсан хоолойн салст бүрхүүлийг нэвчин орохын тулд эмийн бодис нь маш жижиг хэмжээтэй болсон байх хэрэгтэй буюу 5 мкм, түүнээс бага хэмжээтэй болж байж салст бүрхүүлээр нэвчиж орох боломжтой.

Ингэж жижиглэхэд /диспержилт/ эмийн бодис болон утах шингэн нь уур мананцар болж хувирна, энэ нь бараг бидэнд мэдрэгдэхгүй бөгөөд хийж буй эмийн бодис болон уусмалуудаас хамаарч бага зэрэг хүйтэн, эсвэл хоолойд ямар нэг амт мэдрэгдэж болно.

Бүх төрлийн аэрозолийг диспержилтийн зэргээр нь 5 бүлэг болгон хуваана.

- Өндөр дисперсийн (0,5-5мкм)
- Дунд дисперсийн (5-25мкм)
- Бага дисперсийн (25-100мкм)
- Жижиг дуслын дисперсийн (100-250мкм)
- Том дуслын дисперсийн (250-400мкм)

Утлага эмчилгээний вөд анхаарах зүйл

1. Утлага эмчилгээ хийлгэхээс өмнө хамрын нусыг сайн цэвэрлэх ба амьсгалын замыг чөлөөтэй байлгаж утлага хийнэ.
2. Утлага эмчилгээ 10-15 минут үргэлжлэх бөгөөд өдөрт 4,6,8,12,24 цагаар хийж болно. Курс эмчилгээ нь 5-20 удаа өдөр бүр ба өнжөөд хийнэ.
3. Утлага эмчилгээ хийхээс 20-30 минутын өмнө, болон хойно хоол цайгаа идэж уувал зохино.
4. Утлага хийлгээд гадагш гарахдаа ам, хамраа хүйтэн салхи, шорооноос хамгаалж амны хаалт заавал хийнэ.

Утлага эмчилгээний давуу тал

- Эмийн бодис эмгэгтэй хэсэгт шууд очиж үйлчилнэ
- Бусад эрхтнүүдэд эмийн гаж нөлөө гарахгүй
- Цулцан болон гуурсан хоолойд хамгийн өндөр тунгаар нэвчих боломжтой
- Ууж болон тарьж хэрэглэснээс үйлчилгээ илүү хурдан эхэлнэ
- Нярай, бага насны хүүхэд, настайчууд гээд бүхий л хүмүүст хэрэглэхэд тохиромжтой
- Антибиотик эмчилгээг шууд амьсгалын замд оруулах боломжтой
- Гэр болон эмнэлэгт хаана ч хэрэглэж болно



Хүргэлтийн утас
1800-1923, 9508-1923

PRO-115

Хүүхдийн утлагын аппарат



- Ханиад, томуугаас урьдчилан сэргийлэх, эмчлэх үр дүнтэй
- Тоглоомон хэлбэртэй учир хүүхдийн сонирхолыг татна
- Гурван төрлийн масктай учир гэр бүлээрээ хэрэглэж болно
- Хамраар утах нэмэлт хошуутай

PRO



MED-121

Даралтат утлагын аппарат



- Хүүхэд болон том хүнд зориулсан 2 төрлийн масктай
- Эмийн тунг хүүхэд эсвэл том хүнд зориулан тохируулах боломжтой
- Амьсгалын доод замын өвчгөөс сэргийлж үр дүнтэй эмчилнэ



Цайр КОВИД-19 ӨВЧНИЙГ ЭМЧЛЭХ ҮҮ?



Цайр нь хүний биед байдаг хамгийн түгээмэл хоёр дахь эрдэс бодис юм. Цайр нь бүх эд эрхтэн, эсэд нөлөөлдөг микроэлемент бөгөөд хүний биеийн амт, үнэрийн талаарх мэдээллийг боловсруулах үүрэгтэй. Энэхүү бодис нь бодисын солилцоо, дархлааг зохицуулах гол үүрэг гүйцэтгэдэг. Цайрын дутагдал нь хүний биед аргаг ядаргааны синдром, чихрийн шижин, бөөрний өвчин, уушгины хатгалгаа, давтамжтай сепсис зэрэг халдвар болон бусад өвчлөлийг үүсгэдэгийг олон эрдэмтний судалгааны үр дүнд онцолсон байна.

АНУ-ын Эрүүл Мэндийн Үндэсний Хүрээлэнгийн (NIH) мэдээллийн хуудсанд ч энэ талаарх мэдээлэл нийтлэгджээ. Т-лимфоцитийг боловсруулж, идэвхжүүлэхийн тулд хүний бие цайрыг шаарддаг тул энэ элементийг нэмэлтээр хэрэглэж зохистой хэмжээнд барьж байх нь дээрх өвчний эрсдэлээс сэргийлэх чухал алхам гэдгийг зөвлөсөн байна.

Йелийн Анагаах Ухааны Сургуулийн мэдрэл ба иммунобиологийн профессор Дэвид Хафлер "Хэрэв та цайрын дутагдалд орвол таны дархлаа сайн ажиллахгүй гэдэг нь маш тодорхой байна" гэж өөрийн илтгэлдээ онцолжээ. Дээрх баримтуудаас үзэхэд цайр нь Ковид-19 өвчнөөс сэргийлж дархлааг бэхжүүлж чадахыг харуулж байна. Тухайлбал, өнгөрсөн сард Испанийн судлаачид Ковид-19-тэй өвчтөнүүдийн цусан дахь цайрын түвшин бага байгаа нь эрүүл мэндийн байдал тааруухан байгаатай нь хоорондоо холбоотой болохыг тогтоожээ. Тэдгээр эрдэмтэд 3-р сарын 15-наас 4-р сарын 30-ны хооронд Ковид-19 өвчний шинж тэмдэг илэрч, Испанийн Барселона дахь дээд сургуулийн эмнэлэгт хэвтсэн 611 өвчтөний мэдээллийг нэгтгэх зармаар судалгаагаа явуулсан байна. Судлаачдын олж мэдсэнээр эдгээр

Судлаачдын олж мэдсэнээр эдгээр өвчтөнүүдийн 249 нь эмнэлэгт нас баржээ. Нас барсан өвчтөнүүдийн дунд цусан дахь цайрын дундаж хэмжээ нэг децилитр тутамд 43 микрограмм байгааг тогтоожээ. Харин эдгэрсэн өвчтөнүүдийн цусан дахь цайрын дундаж хэмжээ 63 микрограмм байсан нь хэвийн үзүүлэлттэй ойролцоо байв. Судлаачид нас, хүйс, өвчний явц, эмчилгээний төрөл зэрэгт үнэлгээ хийсний дүнд цусан дахь цайрын хэмжээ нэмэгдэх тусам нас барах эрсдэл 7% -иар буурсан болохыг тогтоосон байна. Дээрх судлаачдын дүгнэснээр цусан дахь цайрын хэмжээ нь Ковид-19 өвчин хүндрэх, цаашлаад нас барах эрсдэлтэй шууд холбоотой аж.

Дээрх судалгаанаас дүгнэхэд цайр нь Ковид-19 цар тахлын хор хөнөөлийг бууруулаад зогсохгүй бусад өвчний үед ч эмчилгээний өндөр ач холбогдолтой болох нь батлагдсан байна. Тухайлбал, цайр арьсны бүрэн бүтэн байдал болон бүтцэд чухал үүрэг гүйцэтгэдэг аж. Арьсны өвчтэй, идээт үрэвсэлтэй өвчтөнүүд ихэвчлэн цайрын солилцооны дуталтай, цусан дахь цайрын түвшин буурсан байдаг. Цайр нь ихэвчлэн арьсны үрэвсэл, цочролын үед хэрэглэдэг эмчилгээний тосны найрлагад ордог. Швед улсад хийсэн судалгаагаар цайр нь хөлийн идээт үрэвслийн эдгэрэлтийг түргэсгэж, нянгийн өсөлтийг удаашруулж үрэвслийг дарж байсан байна.

Ореганын их сургуулийн судалгаагаар хоол хүнс болон нэмэлт бэлдмэлээр цайрыг хангалттай авснаар үрэвсэлт өвчнүүдийн эрсдэлийг бууруулдгийг тогтоожээ. Цайр дутагдсанаар аргаг өвчнүүдийн үед үрэвслийн процессыг нэмэгдүүлж шинэ өвчин үүсэх боломжтой болдог ажээ.


Товчхондоо ЦАЙР нь хүнд зайлшгүй хэрэгцээтэй зүйл юм.



Zn

Zinc

Дархлаа дэмжих **BÉRES** бэлдмэл нь найрлагандаа цайрыг зохист тунгаар агуулсан байдаг.



Хүүхдийн хамар яагаад битүүрдэг вэ

Нярай хүүхдийн хамар битүүрэх нь эцэг эхчүүдэд тохиолддог түгээмэл асуудлын нэг юм. Үүний шалтгаан маш олон янз байдаг. Нэн түрүүнд хамрын бүтэц, түүний үүргийн талаар зөв ойлголттой болох нь чухал.

Хамрын хөндий нь агаар дамжуулах, шүүх, цэвэрлэх, чийглэх, бүлээсгэх, агаартай орсон гадны биет, тоос тоосонцор зэргийг гадагш гаргах, дуу авианы долгион дамжуулах, дууны өнгийг бүтээх, дуу авиаг цуурайтуулах, нян устгах үүрэгтэйгээс гадна үнэр амтыг мэдрэх үүрэгтэй эрхтэн юм. Бүтцийн хувьд гадна хамар, хамрын хөндий гэсэн 2 хэсэгтэй. Гадна хамар нь гоо сайхны үүрэгтэй бол хамрын хөндий нь арагшаа гуурсан хоолой залгиур хоолойтой, урагшаа гадаад орчинтой харьцаж дээд доод жим, судаслаг бүс, чихтэй холбогдсон гуурс гэх мэт маш олон нарийн бүтэцтэй. Хамрын хөндий салст давхаргаар хучигдах бөгөөд өөрөөсөө шүүрэл ялгаруулж амьсгалтай хамт гаднаас орж ирсэн нянг устгадаг.

Хүүхдийн салст маш эмзэг, өөрийгөө хамгаалах үйлдэл нь маш сул байдаг учир амархан үрэвсэж хавагнан битүүрдэг байна. Хамар битүүрснээс болж хүүхэд амаараа амьсгалж гаднаас орсон нян уушгинд хүрч хатгалгаа өвчин болон хүндэрдэг. Хамрын салстад үнэрлэхүй болон амьсгалын бүс байдаг. Амьсгалын бүс нь намираа хучуур эдээс тогтох бөгөөд агаартай хамт орсон нянг буцааж хөөн гаргах үйлдэлтэй байдаг.

Гараагүй үлдсэн нянуудыг хамрын салстаас ялгарсан шүүрэл устгадаг.

Хүүхдийн хамрын хөндий анатомын хувьд бүрэн хөгжөөгүй байдаг учир хамар битүүрэх, ханиад хүрэх нь элбэг байдаг. Үүнээс гадна гадаад орчны шалтгаан хүүхдийн хамар битүүрэхэд нөлөөлдгийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

ХЭВТЭЭ БАЙДАЛ

90 градусын налууутай орон дээр удаан хэвтэх тусам хамрын битүү нэмэгддэг. Үүнийг эцэг эхчүүд анхаарах хэрэгтэй. Учир нь хүүхдийн хамрын нүх нарийхан хамар жижигхэн богинохон байдаг. Тиймээс 30-45градусын өндөртэй дэр дэрлүүлж хэвтүүлэх нь хамар битүүрэхээс сэргийлэх тустай. 4-5 нас хүрэхэд нүүрний яс болон хамар томорсоноор хамар битүүрэх нь харьцангуй ховор болдог. Гэхдээ ханиад томуу туссан үед том хүний ч хамар битүүрдэг шүү дээ.

ХАЛУУН ӨРӨӨ ТАСАЛГАА

Амьдарч буй гэр орчны агаар хэтэрхий халуун эсвэл хэтэрхий хуурай байх нь хамар битүүрэх нэг шалтгаан болно. Тиймээс өрөөний агаарыг чийгшүүлж салхивчаа онгойлгон агаараа сэлгэж байх хэрэгтэй.

ХУУРАЙ, ТООСЖИЛТТОЙ ӨРӨӨ

Өрөөний агаарын тоосжилт их байхын хэрээр хүүхдийн хамар битүүрнэ. Учир нь насанд хүрсэн хүмүүс агаарт байгаа тоосонцорыг намираа хучуур эдийн тусламжтай шүүж цааш нэвтрэхээс сэргийлдэг бол нялх хүүхдэд энэ хучуур эдийн хөгжил дутуу учир тоосыг шүүж чадахгүй хамар нь амархан битүүрдэг байна.

ГУЛГИХ

Хүүхэд нярай үедээ гулгих нь элбэг. Зарим тохиолдол хамар, залгиураар гулгих нь ч бий. Энэ үед хөхний сүү хамрын хөндий рүү орсон сүү тэндээ хатаж хүүхдийн хамар битүүрэх нэг шалтгаан болдог аж. Иймээс гулгисан дарууд хүүхдийн хамрыг шалгаж, цэвэрлэж байх нь чухал юм шүү.



БУРУУ ЦЭВЭРЛЭХ

Хүүхдийн хамрыг тогтмол буюу өдөрт хамгийн багадаа 1 удаа цэвэрлэх хэрэгтэй. Ингээгүйгээс болж хамар битүүрч ханиад томуу даамжрах, цаашлаад чих өвдөх зэрэг хүндрэлүүд гарах аюултай. Мөн хүүхдийн хамрыг амаараа сорох, хөхний сүү дусаах зэрэг зориулалтын бус зүйлээр цэвэрлэх гэж оролдох нь хүүхэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүйг эцэг эхчүүд анхаарах хэрэгтэй.

ХАМРЫН ХЭРХЭН ЯАЖ ЗӨВ ЦЭВЭРЛЭХ ВЭ?

1. Нэн түрүүнд хүүхдийн хамар цэвэрлэгч зориулалтын дусаалга, эсвэл буцалсан бүлээн ус хүүхдийнхээ хамрын үүд хэсэгт /нүх тус бүрд/ 2 дуслыг дусаагаад чийглэж өгөөрэй. Хэрэв хэт гэдийлгэж дусаах юм бол хүүхэд цочиж уйлахаас гадна хамрын хөндийн салст гүйцэт чийглэгдэхгүй. Дусаасны дараа хэсэг тайван хэвтүүлж байгаад хүүхдийг доош харуулан хэвтүүлнэ. Энэ үед хүүхэд бага зэрэг уйлж магадгүй. Гэхдээ үүнд санаа зоволтгүй. Ингээд хэсэг хугацааны дараа хамрын нус бага багаар гарч ирэхэд хөвөн болон зөөлөн материалтай, янз бүрийн саван спиртийн агууламжгүй нойтон салфетикаар нусыг цэвэрлэнэ.

2. Хүүхдийг доош харуулж хамрыг нь цэвэрлээд нус гүйцэд гарахгүй бол хөвөнг зулын гол шиг имрэн ороож, буцалсан бүлээн усанд дүрж чийглээд хүүхдийн хамарт ээлжлэн хөвөнгөө нар зөв эргүүлж хийгээд нар буруу эргүүлэн буцааж гаргаж авна.

Хөвөнгөө зулын гол шиг олноор нь ирмэж бэлдээд ариун уутанд хадгалчихвал өдөр бүр цэвэрлэхэд амар байх болно шүү.

Хүүхдийнхээ хамрыг цэвэрлэхдээ зориулалтын шингэн, дусаалгыг хэрэглэж байхыг зөвлөж байна. Энэ нь хүүхдийн хамрын хөндийд ямар нэгэн зовиур, сөрөг нөлөө үзүүлэхгүй, хамрыг үр дүнтэй цэвэрлэхэд туслана.

Танд Италийн алдарт Chicco брэндийн хүүхдийн хамар цэвэрлэх дусаалгыг санал болгож байна. Энэхүү бүтээгдэхүүнийг Монгол Эм Импэкс Концерны Улаанбаатар хотын болон орон нутгийн 21 аймагт байрлах салбаруудад худалдаалж байна. Мөн **1800-1923** болон **9508-1923** дугаарт залгаж Улаанбаатар хот дотор хүргэлтээр авах боломжтой.





Венну

Тоос сорогчинд залгадаг
хамар цэвэрлэгч

Венну

Хүүхдийн хамар
цэвэрлэгч



Айх хэрэггүй

Энэхүү бүтээгдэхүүн нь тоос сорогчны хүчээр биш тоос сорогчны жигд урсгалыг ашиглан сул хүчээр сорж хамрын бохирдлыг цэвэрлэдэг тул хүүхдэд ямар нэг аюулгүй, сөрөг нөлөөгүй.

Хүүхдийн хамар цэвэрлэгчийг хэрэглэх заавар

Хүүхдийн хамар цэвэрлэгчийн хонх хэлбэрийн төгсгөлийг ахуйн хэрэглээний тоос сорогчны хоолойд холбоно. Тоос сорогчоо асаан соролтын хүчийг салхивчаар тохируулна. Үүний дараа сорогч төгсгөлийг хүүхдийн хамарт тааруулна. Ингэснээр сорох хүчний дагуу хүүхдийн хамар дахь бохирдол хөдлөн сорогчид орно. Дундуур нь тасалдалтайгаар хэд хэдэн удаа үйлдлийг давтаж болно.

Доорхи тохиолдлуудад хамар цэвэрлэгчийг анхааралтай хэрэглэнэ

- Хэрэв хамрын дотор шархлаа үүссэн
 - Хамраас цус гарах магадлал өндөртэй
 - Гемофилийн өвчтэй тохиолдолд
- Эдгээр тохиолдлуудад хамар цэвэрлэгчийг болгоомжтой хэрэглэнэ.

Хүүхдийн хамар цэвэрлэгчийг ариутгах


Хуванцар хэсгүүд болон силикон гуурс нь халуунд тэсвэртэй тул хэрэглэхийн өмнө буцалж буй усанд юмуу ариутгалын бодисод ариутгаж болно. Цэвэрлэхдээ хамар цэвэрлэгчийн сорох хошууг салгана. Илүү үр дүнтэй цэвэрлэхийн тулд хошууны урд хэсгийг мөн салгаж болно. Хатаасны дараа хэсгүүдийг угсран цэвэрхэн газар хадгална уу.

Ариутгахдаа богино долгионы төхөөрөмж хэрэглэхийг хориглоно!




Зохиогчийн эрх
баталгаажсан

Салгаж цэвэрлэхэд хялбар



Монгол Эм Импэкс
Концерн

Хүргэлтийн утас: 9508-1923, 9508-1923



Фтор ба эрүүл шүд

Нэмэлтээр фтор хэрэглэх нь шүдэнд хэрхэн нөлөөлдөг вэ?

Шүд хорхойтох өвчин нь өнөөгийн ихэнх улс орнуудад өргөн тархсан ужиг эмгэгийн нэг билээ. Энэ эмгэг бүхий л насныханд тохиолдох боловч хүүхэд болон залуу үеийнхэн өвчлөлд илүү ихээр өртөж байна. Шүд цоорох үйл явц нь шүдний хатуу эдийг цоолох ба улмаар шүдний өнгөрт агуулагдах бичил биетүүдээс үүссэн хүчил шүдийг эрдэсгүйжүүлэн гэмтээх замаар явагддаг.

Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагаас хүн амын шүд, амны хөндийг эрүүлжүүлэх нь хүний биеийн бүхий л эрхтэнд нөлөөлөх, байнгын голомтот халдварыг багасган эрүүлжүүлэх чухал хүчин зүйл гэж үзэж байна.

Фторыг шүд цоорол зогсоох үйлчилгээтэй бодис, шүд хорхойтохыг удаашруулагч байдлаар ашиглаж ирсэн урт түүх бий. Энэ түүх нь шүд ургахын өмнөөс эхлэн фторыг хэрэглэвэл шүдний паалан хүчиллэг орчинд илүү тэсвэртэй, бат бөх бүтэцтэй болдог тухай 1942 онд баталсан Дин эмчээс эхлэлтэй.

Фторын тухай сонирхолтой мэдээллүүд



Бидний шүдэнд цоорол үүсгэдэг гол буруутан нь элсэн чихэр биш харин тэдгээрээр хооллодог идэмхий хүчил үзүүсгэг нян, бактери юм.

Фтор нь байгалийн гаралтай эрдэс бодис бөгөөд шүд цоорох өвчнөөс урьдчилан сэргийлж, тэр ч байтугай нэгэнт хорхойтсон шүдийг нэмж хорхойтохоос сэргийлэх үйлдэл үзүүлдэг нь батлагдсан.



Фторид бол фторын органик бус ион юм. (бидний сайн мэддэгчлэн Менделеевийн үелэх системийн F элемент)



Фторидын нөлөөгөөр паалангийн уусамтгай чанар буурч, паалангийн эргэн эрдэсжих процесс явагдах боломжтой болдог.

Бага насандаа хангалттай хэмжээний фтор авах нь бидний амьдралын туршид шүдээ бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг.



Фторыг системтэйгээр уух, хэсэг газар хэрэглэх нь хамгийн үр дүнтэй аргад тооцогддог байна.

Фтор нь үелэх системийн элементүүд дунд хамгийн өргөн тархснаараа 13-д жагсдаг бөгөөд байгаль дээр ус, агаарт элбэг тархсан байдаг.



ҮТРЭЭНИЙ ХЭВИЙН БИЧИЛ ОРЧИН ГЭЖ ЮУ ВЭ?

Яагаад чухал гэж?

Эрүүл эмэгтэйн үтрээнд маш олон тооны бичил биетэн буюу тогтвортой микрофлора агуулагдах бөгөөд тэдгээр бичил биетүүд үтрээний орчинг тэнцвэржүүлж элдэв өвчин үүсгэгч нянгаас хамгаалж байдаг. Хэвийн үед үтрээний 1 грамм шүүрэлд 100 мянга орчим бактер агуулагддаг бөгөөд эдгээрийн ихэнх нь ашигтай нян буюу лактобактери байдаг аж.

Үтрээ бол хоол боловсруулах эрхтний дараа орох хүний биеийн хамгийн их ашигтай бичил биетэн агуулдаг эрхтэн бөгөөд тэдгээр биетүүд үтрээнд байх нь үтрээнд өөрт нь олон талын чухал ач холбогдолтой юм.

Үтрээний ашигтай бичил биетэн буюу нян дараах үүрэг гүйцэтгэнэ:

- Их хэмжээгээр оршдог ороо үтрээнд нэвтэрсэн хор хөнөөлтэй нянгуудыг тооны хувьд давамгайлж устгадаг.
- Үтрээний орчны хүчил, шүлтийн тэнцвэрт байдлыг хадгална. (үтрээнд хүчиллэг орчныг бүрдүүлнэ)
- Үтрээнд нэвтэрсэн бусад нянгуудыг устгах эсвэл тоог нь багасгах үйлчилгээтэй сүүн хүчлийг ялгаруулна.
- Биологийн гаралтай антибиотик болох бактериоцин ялгаруулж үтрээнд нэвтэрсэн халдварын нянг устгах буюу тоог нь цөөрүүлдэг.



Үтрээний ашигтай бичил биетүүдийн тэнцвэр алдагвал үрэвсэл болон халдвар тархах таатай нөхцөл бүрэлдэж эхэлдэг.

• Үтрээнд нэвтэрсэн халдварын нянг үтрээний салстад бэхлэгдэн, эдийг гэмтээхээс хамгаалдаг бодис ялгаруулан хориг тавьдаг.

Үтрээний ашигтай нянгийн нэг болох лактоацилл нь үтрээний хүчил шүлтийн орчныг (pH орчин) хэвийн хэмжээнд (pH3,8- 4.2) хадгалахад оролцож, бусад нянгуудын өсөлтийг хязгаарладаг. Хэрвээ үтрээний pH нэмэгдвэл (илүү шүлтлэг болох), лактоацилл нянгийн тоо, хэмжээ, чанар буурч, бусад нянгийн тоо нэмэгдэнэ. Үүнээс шалтгаалж үтрээний үрэвсэл, халдвар газар авч, загатнах, цочрох, ялгарал өөрчлөгдөх зэрэг зовиур илэрнэ.

Үтрээний хэвийн бичил орчин өөрчлөгдөхөд нөлөөлөх хүчин зүйлүүд:

- Антибиотикийн зохисгүй хэрэглээ
- Үтрээг савангаар угаах
- Архаг өвчлөл, эмгэгүүд. Чихрийн шижин зэрэг бодисын солилцооны эмгэгүүд үтрээ хуурайшихад нөлөөлнө.
- Стресс төрөх
- Дархлаа дарангуйлагдах
- Дааврын өөрчлөлт

Үтрээний хэвийн бичил орчин өөрчлөгдөхөд илрэх шинж тэмдэг:

- Үтрээнээс эвгүй үнэр гарах
- Загатгах
- Хорсох
- Үтрээ хуурайших
- Үтрээний шүүрэл ихсэх

Дээрх шинж тэмдгүүд илэрвэл эмчид хандахыг зөвлөж байна.



ГИНОФИЛУС

ҮТРЭЭНИЙ АШИГТАЙ БИЧИЛ БИЕТЭН АГУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН

ҮТРЭЭНИЙ КАПСУЛ БОЛОН УДААШРУУЛСАН
ҮЙЛДЭЛТЭЙ ҮТРЭЭНИЙ ШАХМАЛ

ХЭРЭГЛЭХ ЗААЛ

- Үтрээний бичил орчны тэнцвэр алдагдахаас урьдчилан сэргийлэх
- Үтрээний бичил орчинг сэргээх
- Үтрээний бактер мөөгөнцрийн халдварын дахилтаас сэргийлэх
- Хэсгийн антибиотик болон мөөгөнцрийн эсрэг ууж хэрэглэх эмийн эмчилгээний үед үтрээний бичил орчинг тэнцвэржүүлэх зорилгоор хавсран хэрэглэнэ.
- Жирэмсний бүх хугацаанд болон хөхүүл үед хэрэглэж болно.



ГИНОФИЛУС КАПСУЛЫГ ХЭРЭГЛЭХ АРГА /14 ШИРХЭГТЭЙ/

Гинофилус үтрээний капсулыг орой унтахын өмнө 1 ширхэгээр 14 хоног хэрэглэх ба шаардлагатай тохиолдолд өглөө 1, орой 1 капсулыг 7 хоногийн турш хэрэглэнэ.

Бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө болон хэрэглэсний дараа гараа сайтар угаана.

Капсулыг 4-5 секундын турш усанд дүрэн сайтар норгосны дараа үтрээнд гүн хийж хэрэглэнэ.

Гинофилус нь үнэргүй бөгөөд толбо үүсгэхгүй.



ГИНОФИЛУС УДААН ҮЙЛДЭЛТЭЙ ШАХМАЛЫГ ХЭРЭГЛЭХ АРГА /6 ШИРХЭГТЭЙ/

Гинофилус удаан үйлдэлтэй үтрээний шахмалыг орой унтахын өмнө хэрэглэнэ.

Уртасгасан үйлдэлтэй учир 4 хоногт 1 шахмалыг орой унтахын өмнө нийт 24 хоног хэрэглэнэ.

Бүтээгдэхүүнийг хэрэглэхийн өмнө болон хэрэглэсний дараа гараа сайтар угаана.

Шахмалыг 4-5 секундын турш усанд дүрэн сайтар норгосны дараа үтрээнд гүн хийж хэрэглэнэ.

Гинофилус нь үнэргүй бөгөөд толбо үүсгэхгүй.

Эмчилгээний үед: Гинофилус бүтээгдэхүүний илүүдэл нь үтрээнээс гарч болох ба энэ нь хэвийн зүйл юм.
Хэрэв капсулыг сайтар норгоогүй бол хайлаагүй үлдсэн хэсэг гарч болно.
Эмчилгээний үед бэлгийн харьцаанд орж болно.

АНХААРУУЛГА: Гинофилус бэлдмэлийг зөвхөн үтрээгээр хэрэглэнэ. Хүүхдээс хол байлгана уу!



Монгол Эм Импэкс
Концерн

Хүргэлтийн захиалга өгөх утас:
1800-1923, 9508-1923

МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРНЫ 21 АЙМГИЙН САЛБАРЫН БАЙРШИЛ

СҮХБААТАР АЙМАГ

- 📍 Сүхбаатар аймаг, Баруун урт сум,
7 дугаар баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 705 1-0090

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ

- 📍 Баян-өлгий аймаг, Өлгий сум,
5 дугаар баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7042-2754

БУЛГАН АЙМАГ

- 📍 Булган сум, 5-р баг Чин Ван Ханддоржийн
гудамж, Эрүүл мэндийн газрын зүүн талд
- ☎ Холбоо барих утасны дугаар 7034-2034

ДАРХАН-УУЛ АЙМАГ

- 📍 Дархан уул аймаг, Дархан сум,
15 дугаар баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7037-7502

ДОРНОГОВЬ АЙМАГ

- 📍 Дорноговь аймаг, Сайншанд сум, 2-р баг
Дэнжийн байр
- ☎ Холбоо барих утасны дугаар 7052-2621

ДОРНОД АЙМАГ

- 📍 Дорнод аймаг, Хэрлэн сум, 7-р баг Гаалийн
газрын баруун тал
- ☎ Холбоо барих утасны дугаар 70584641

ДУНДГОВЬ АЙМАГ

- 📍 Дундговь аймаг, Сайн цагаан сум,
7 дугаар баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7059-2416

ӨМНӨГОВЬ АЙМАГ

- 📍 Өмнөговь аймаг, Даланзад сум, 3-р баг БОЭТ-н
баруун тал
- ☎ Холбоо барих утасны дугаар 7053-3008

СЭЛЭНГЭ АЙМАГ

- 📍 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум,
3 дугаар баг 1 дүгээр хэсэг
- ☎ Утасны дугаар: 7036-2348, 7036-2585

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

- 📍 Сүмбэр сумын 2-р баг, Цахилгаан түгээх
Сүлжээ салбарын баруун талд
- ☎ Холбоо барих утасны дугаар 7054-3020

БАЯНХОНГОР АЙМАГ

- 📍 Баянхонгор аймаг, Дуурсах
3 дугаар баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7044-2978

ТӨВ АЙМАГ

- 📍 Төв аймаг, Зуун мод сум, 1-р баг, Худалдааны
гудамж
- ☎ Холбоо барих утасны дугаар 7027-3847

ХЭНТИЙ АЙМАГ

- 📍 Хэрлэн сум, 1-р баг, Тэмүүжингийн
гудамж
- ☎ Холбоо барих утасны дугаар 7056-2114

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ

- 📍 Өвөрхангай аймаг, Арвайхээр
5 дугаар баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7032-2492

АРХАНГАЙ АЙМАГ

- 📍 Архангай аймаг, Эрдэнэбулган сум,
1 дүгээр баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7033-2043

ЗАВХАН АЙМАГ

- 📍 Завхан аймгийн Жинст багийн Төвийн хэсгийн
10 Б хэсэг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7046-3743

УВС АЙМАГ

- 📍 Увс аймаг, Улаангом сум, 3-р баг, Нэгдсэн
эмнэлгийн дэргэд
- ☎ Утасны дугаар 7045-2193, 7045-3781

ОРХОН АЙМАГ

- 📍 Орхон аймаг, Баян өндөр сум, Бүрэн бүст баг,
5-р микро Цэнхэр аптекийн байр
- ☎ Утасны дугаар 7035-2634, 7035-0135

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

- 📍 Есөнбулаг сум, Харзат баг 336 байр, 2-р эмийн
сан, Есөнбулаг сум
- ☎ Холбоо барих утасны дугаар 7048-3591

ХӨВД АЙМАГ

- 📍 Жаргалант сум, Магсаржав баг, Вансэмбэрүү
эмийн сангийн байр, Хишиг плаза төв 1 давхар
- ☎ Холбоо барих утасны дугаар 7043-3060

ХӨВСГӨЛ АЙМАГ

- 📍 Хөвсгөл аймаг, Мөрөн сум,
8 дугаар баг
- ☎ Холбоо барих утасны дугаар 7038-2556

МОНГОЛ ЭМ ИМПЭКС КОНЦЕРНЫ УЛААНБААТАР ХОТЫН САЛБАРЫН ХАЯГ, БАЙРШИЛ

ТЭНГИС САЛБАР

- ТЭНГИС кино театрын замын урд талд, БИШРЭЛТ худалдааны төвийн баруун жигүүр

ОФИЦЕР САЛБАР

- Офицеруудын ордон WELLMART худалдааны төвийн 1-р давхарт

ЦАЙЗ САЛБАР

- ЦАЙЗ 16-р хороолол, WELLMART худалдааны төвийн 1-р давхарт

ХАРХОРИН САЛБАР

- 1-р хороолол, ХАРХОРИН захын хойно ПИРАМИД үйлчилгээний төв

АНДУУД САЛБАР

- ТБД Андууд худалдааны төвийн НОМИН супермаркетын 1 давхарт

ТАВАН ШАР САЛБАР

- Таваншар автобусны буудлын баруун талд, төв замын хойд тал

БОТАНИК САЛБАР

- Ботаникын автобусны буудал, WELLMART худалдааны төв

ТӨГӨЛДӨР САЛБАР

- МУБИС-н зүүн талд ТӨГӨЛДӨР ТӨВ-н 1-р давхарт

ЭЛЭГ ТӨВ САЛБАР

- Континентал зочид буудлын зүүн урд, Далай цамхагийн 1-р давхарт

И-МАРТ ЧИНГИС САЛБАР

- Чингис зочид буудлын хойно И-март худалдааны төвийн 3-р давхарт

И-МАРТ ХАН-УУЛ САЛБАР

- И-Март Хан-Уул худалдааны төвийн 2 давхарт

ТӨВ САЛБАР

- Нарны зам, Тэвэрчдийн гудамж-28, Монгол Эм Импэкс Концерны төв байр

ОД САЛБАР

- 4-р хороолол ОЮУНЫ УНДРАА цогцолбор, CAPITAL TOWN, WELLMART худалдааны төв

НИСЭХ САЛБАР

- Нисэхийн 58-р байр, WELLMART худалдааны төв дотор

ТОПАЗ САЛБАР

- АШУҮИС-Сувилахуйн сургуулийн зүүн талд байрлах ТОПАЗ эмнэлгийн 1-р давхарт

ГССҮТ САЛБАР

- Гэмтэл Согоо Судлалын Үндэсний Төвийн 1 давхарт

АМГАЛАН САЛБАР

- Нийслэлийн Амгалан амаржих /3-р төрөх/ газрын 1-р давхарт

50 МЯНГАТ САЛБАР

- Улаанбаатар их дэлгүүрийн замын хойно, Голомт банкны эзэлийн төвийн зүүн талд

ТОВЧОО САЛБАР

- БЗД товчоо, Сансар худалдааны төвийн 1 давхарт

НОМИН САЛБАР

- Баруун 4 зам, Номин худалдааны төвийн 1-р давхарт

ХАНГАЙ САЛБАР

- Хангай хотхоны баруун талд, Номин худалдааны төв дотор

ЯАРМАГ САЛБАР

- Яармаг явах замд Номин моторс худалдааны төвийн В1 давхарт

ЗУНЖИН САЛБАР

- Зунжин явах зам дагуу Номин худалдааны төвийн 1 давхарт

СИТИ МОЛЛ САЛБАР

- Хавдар Судлалын Үндэсний Төвийн зүүн талд Сити Молл худалдааны төвийн 1 давхарт